

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 15.00 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн, ажлын хэсгийн гишүүд Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Дуламсүрэн, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Ил тод сангийн тэргүүн н.Цэрэнжав, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Татварын ерөнхий газрын хэлтсийн дарга Пүрвээ, Газрын тосны газрын хэлтсийн дарга Чулуунбат, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Цэгц, Монросцветмет ХХК-ийн мэргэжилтэн Ашидмөнх, Бороо гоулд ХХК-ийн дэд захирал Сандаг, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Ерөнхийлөгчийн зөвлөх А.Эрдэнэдорж, Нүүрс ассоциацийн мэргэжилтэн Сарангэрэл, Монголын ажил олгогч эздийн холбооны ажилтан Жанцан, Монголын нягтлан бодох институтын ажилтан Жаргалсайхан, Тунгалаг нар оролцов. Мөн хуралдаанд ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг, Эрнст энд Янг Монголиа Аудит компанийн захирал Александр Чин, менежер Питер Вонг, аудитор н.Алтансүх, Б.Батзаяа, Л.Оюу-Эрдэнэ нар оролцов. Хуралдааны ирц ажлын хэсгийн 25 гишүүнээс 15 ирж, 60 хувьтай байлаа.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн нээж хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмыг танилцуулж батлуулав.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2007 оны нэгдсэн тайлангийн тухай танилцуулга (Эрнст энд Янг компанийн концерциум)

Б.Эрдэнэсүрэн. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2007 оны нэгдсэн тайлангийн тухай танилцуулгыг тус компанийн холбогдох хүмүүс танилцуулна.

Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор Алтансүх үгийнхээ эхэнд манай захирал Александр Чин, менежер Оливия болон бусад аудиторуд маань өнөөдөр энд ирсэн байгаа гэж цохон тэмдэглэв Тэрээр танилцуулгыг дэлгэрэнгүй хийв. (Дэлгэрэнгүй тайланг монгол, англи хэл дээр гаргасныг гишүүдэд урьдчилан хүргэсэн бөгөөд энэхүү тэмдэглэлд хавсаргав).

Б.Эрдэнэсүрэн-Тайлангаас асуух асуулт байвал гишүүд асууна уу.

Н.Дорждарь: Бас нэлээн зөрүү гарчээ. Энэ тайланд ороогүй томоохон татвар төлөгч байгаа юу?

Э.Сумъяа: Шийдэгдээгүй зөрүүнүүд их байна. Ялангуяа 3,3-т байгаа зөрүүтэй тоог асууж байна. Хүснэгтэд хураамж 12 тэрбум гэсэн байна, гэтэл өмнөх хүснэгт дээр чинь төлбөр 12 тэрбум байсан. Энэ орчуулгын алдаа юу, эсхүл аль алин дээр нь ийм зөрүү байна уу?

Алтансүх: Тийм байна. Орчуулахдаа алджээ. Төлбөр дээр энэ зөрүү гарсан.

Э.Сумъяа: Одоо жишээ нь энэ 12 тэрбумаа задлаад тэр нь тийм юмнаас болсон гээд тайлбарлах боломж байгаа юу?

Алтансүх: 27 дугаар хуудсан дээр задаргаа нь ерөнхий дүнгээрээ байгаа.

Э.Сумъяа: Энд хэдхэн том компаниас болж ихэнх зөрүү гарчээ. Тэгэхээр тэр компаниудын нэрээр тэр зөрүүгээ харуулах боломжтой юу?

Алтансүх: Тэгж харуулж болно.

Б.Эрдэнэсүрэн: Энэ Монгол газар, Эрдэнэт, Алтан дорнод монгол компаниудаас гадна энэ зөрүүнд томоор нөлөөлж байгаа компаниуд байна уу?

Оливия: Монполимет, Монросцветмет, Таван толгой зэрэг компаниуд дээр том зөрүү бас гарсан байгаа.

Александр: Бид компани болон Засгийн газраас авсан дүнгүүдээ харьцуулж үзээд анхны зөрүүг гаргасан. Харин шийдвэрлэх боломжтойг нь шийдвэрлээд шийдвэрлэсэн зөрүүг гаргасан байгаа.

Б.Эрдэнэсүрэн: За саналаа хэлье.

Н.Алагаа: 2006 оны тайлангаас 25 тэрбумын зөрүүг шийдвэрлэгдээгүй үлдсэн. Энэ жил дахиад л 25 тэрбум зөрчихөж. Урьдны тайлан дээр гарсан алдаа, оноон дээр суралцсан юм байна уу? Засгийн газрын байгууллагуудаас өгсөн тоон дээр хариуцлагатай хандах хэрэгтэй. Жил бүр 25 тэрбумын зөрүү гардаг, учир нь олддоггүй ийм жишиг тогчихвол хэцүү байна. Энэ нь бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийг шуурхай болгох шаардлагатай харуулж байна.

Н.Дорждарь: Засгийн газар болон 38 компани болгоноор ямар зөрүү гарч байгааг харуулсан хүснэгт гаргаж тайланд оруулах, нөөц ашигласны төлбөрийг төлбөрөөс тусгайд нь салгаж гаргах, гарч байгаа зөрүүнээс том зөрүү болгоныг тусгайлан тайлбарлах хэрэгтэй байна. Ер нь нөөц ашиглалтын төлбөрийг тусад нь гаргаж өгч болох уу? Зөрүүнүүд дээрээ ийм тийм учраас энэ зөрүү гарлаа гээд тайлбарлавал зүгээр байна.

Алтансүх: Компани тус бүрээр болон нөөц ашиглалтыг тусад нь гаргая.

Б.Эрдэнэсүрэн: Татварын ерөнхий газрын хэлтсийн дарга Пүрэвээс асууя. Энэ Таван толгой дээр ногдол ашгийг орон нутагт төлсөн нь татвараас ирсэн тайлан дээр тусгагдаагүй байдаг нь ямар учиртай юм бэ?

Пүрэвээ: Уул нь татварт аудитлагдсан тайлангаа өгч байгаа, тэр тоогоо ОУИТБС-ын тайланд тавьж байгаа. Тэгэхээр зөрөөд байна гэдэг чинь та бүхэн аудитаас өмнө тайлан аваад байна уу, компани 2 тайлан гаргаад байдаг юм уу, гарах ёсгүй л юм байгаа юм. Сумын түвшинд тэр төлбөр, татвар, ногдол ашиг энэ тэрийг тус тусад нь бүртгэхгүй бөөнд нь бүртгээд байдаг асуудал байгаа. Мэдээллийн урсгал болохгүй байна, хуулиар Ашигт малтмалын газарт тайлагнах ёстой байдаг, үүнийг татварын албанд хариуцуулаад байдаг. Ер нь тайланг олон газар гаргадаг, тэр нь хоорондоо зөрдөг, агентлагуудын авдаг мэдээллийг цөөлөх ёстой, агентлаг болгон мэдээлэл авах сонирхолтой, амбицтай болоод байна. Хандивыг зөвхөн компанийн захирал л мэддэг, бусад нь мэддэггүй. Байгаль орчны мэдээг сум, яамны төвшинд мэдээг хэн хэзээ гаргах вэ?, Ашигт малтмалын газар дээр хэн гаргах вэ?, хөдөлмөр, халамжийн газар гадаадын ажиллагчдын төлбөрийн квотод байгааг нь аваад, квотоос илүүг нь сумыг ав гэдэг, Ийм янз бүрийн газраас гардаг мэдээг татварын байцаагч бүгдийг нэгтгэн ирүүлнэ гэж зааварт байгааг анхаарах хэрэгтэй. Тайлангаар гарсан зөрүүг үндэслэж хариуцсан улсад нь семинар өгөх хэрэгтэй байна.

Н.Алгаа: Татварыг зөвхөн хуулиар тогтоодог. Гэтэл Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгдийн хурал тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс 2 сая төгрөг, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс 1 сая төгрөг жил бүр авахаар шийдвэр гаргасан байсныг манайх Засгийн газарт хүргүүлсэн. Энэ бол хууль бус шийдвэр юм.

Жанцан: 2006 оны тайлан их дэлгэрэнгүй гарсан, За би энэ орчуулга маш муу байна гэж хэлмээр байна. Мөн аль компани улсын төсөвт юу оруулав гэдгийг харах боломжгүй байна. Улсын эдийн засагт уул уурхайн оруулсан хувь нэмэр бас харагдах юм алга. Энэ талаар дахиад ажилламаар байна.

Александр: Бид та бүхний гаргасан саналуудыг ойлгож байна. Энэ тайланг сайжруулах арга хэмжээг авна. Бид эхний тайланд компани тус бүрээр хоёр дахь тайланд нийлбэрээр нь харуулсан байгаа.

Б.Эрдэнэсүрэн: За энэ санал болгонд буцааж тайлбар хэлээд баймааргүй байна. Бид хоорондоо ярилцаж байгаад та бүхэнд саналуудаа нэгдсэн байдлаар гаргаж өгөө. Тэгээд та нар хүлээж авах боломжоо хамгийн сүүлд нь хэлээрэй.

А.Эрдэнэдорж: Петрочайна компани дээр тодруулга хийгээд Гаалийн татварын газраас тодруулга хийгээд байсан, энд гэтэл анхны дүнгээрээ шийдвэрлээгүй гэсэн зөрүүн дотор байж байна шүү дээ.

Алтансүх: За бид үүнийг тодруулъя.

Жаргалсайхан: Бид мэргэжлийн үүднээс харахад энэ тайланг арай илүү нарийвчилж харуулах хэрэгтэй юм шиг санагдлаа. Тоог мянгачилсан байдлаа бүгдийг нь шалгаж засаарай, ойлгомжгүй байна шүү. Зарим дээр нь мянгачлаад зарим дээр нь нэгжийг нь бичээгүй байна. Дүгнэлтэн дээр бас алдаа байна. Эдгээр тоонуудыг гаргахдаа анхан шатны баримттай нь тулгасан юм уу, эсхүл зүгээр л хоёр тоог харьцуулж байна уу? Бас та нар хуралдаан дээр хийсэн үзүүлэнгээ хүмүүсийн цаг авсан байдлаар танилцуулж байна.

Э.Сумъяа: За надад хэдэн санал байна. Нэгт, англи монгол орчуулга хоорондоо зөрөөд таарахгүй байна. Орчуулгаа дахиж нягтал. Хоёрт, компани тус бүрээр болон зөрүү тус бүрээр нэгтгэсэн байдлаар тусад хүснэгт гаргаж харуулмаар байна. Гуравт, зөвлөмж дүгнэлтээ арай дэлгэрэнгүй авмаар байна.

Н.Дорждарь: Та нар анхан шатны баримт үзсэн үү? Ажлын удирдамж дээр онцгой тохиолдолд анхан шатны баримт үзнээ гээд заачихсан байгаа.

Алтансүх: Зөрүү нь тодруулган дээрээ тодрохгүй байгаа компаниуд дээр биеэр очиж ажилласан. Очсон компаниуд дээрээ анхан шатны баримт үзсэн. Очоогүй компаниудаас тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан тайлангийн тодруулгыг авсан.

Сарангэрэл: Орчуулгын алдаа байгаа нь ойлгомжтой байна. Орчуулгын алдаанаас гадна техникийн алдаа бас байна. Монгол Улсад байхгүй төлбөрийн нэр бичсэн байна. 25 тэрбумын зөрүү гарсан байхад ганц хуудас тодруулгатай үлдмээргүй байна. Бас мэдээлэл авах боломжгүй гэсэн тайлбар хэцүү сонсогдож байна. Дараа дараагийн аудиторуд баахан зөрүү гаргаж хаячихаад мэдээлэл авах болмжгүй байсан тул шалтгаан нь тодроогүй гээд байдаг жишигтэй болчих вий.

Б.Эрдэнэсүрэн: Энэ ажлын явцад би аудиторудтай уулзаж байсан, мөн эд нарын яаж ажиллаж байсныг ч мэднэ. Маш их хөдөлмөр орсон нүсэр ажил байсан гэдгийг хүлээн зөвшөөрнө. Харин хийсэн ажлаа хүнд ойлгуулах тал дээр болон орчуулга дээр маш муу ажилласан байна. Өөрсдийн хийсэн тэр их ажлаа муу тайлбарлаж унагаж байна. Өөрөөр хэлбэл огт бэлтгэлгүй байна. Ийм маягаар Үндэсний зөвлөлд орвол унана шүү. Сайн бэлдэж орчуулга, яриа энэ тэрдээ анхаар. 25 тэрбумын зөрүү 4 хөн юмнаас гарч байгаа. Тэгэхээр 25 тэрбум гээд айгаад байх шаардлагагүй ээ. Зөвлөмжөө тодорхой болго. Ийм юман дээр анхаар гээд. Дахиж Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулая. Дараа нь Үндэсний зөвлөлөөр оруулна биз. Үүн дээр Алтандорнодыг хасмаар байна. Нэгэнт Монгол Улстай татварын талаар олон улсын арбитра дээр маргаад байгаа айлыг бид 8 тэрбумын зөрүүг аудитаар олж тогтооно гээд

явах нь утгагүй биз ээ. Гишүүд үүн дээр ямар бодолтой байна? Зөрүүг 38 компани дээрээ нэгтгээд тайлагнах

Оливия: Би нэг зүйл асууя. Тавантолгой мэдээллээ гаргаж өгөхөөс татгалзаад байгаа. Тавантолгой компани тодруулга өг гэхээр нябод хэл гэдэг, нябо нь болохоор захирал битгий өг гэсэн гэдэг. Энэ компанийг яах вэ?

Б.Эрдэнэсүрэн: Шийдвэрлэгдээгүй зөрүүг гол том асуудлууд дээрээ барьж гаргах, ярих, тухайлбал, Эрдэнэт 8.9 тэрбум гээд 4 том тоо л 21 тэрбумыг бий болгож байгааг тодруулах хэрэгтэй. Гишүүдийн гаргасан санал нэг бүрийг авч үз. Эрдэнэдоржийн гаргасан Тамсагийн сналыг судал. Зөрүүн дээр хайшаа ч хөдлөхгүй хариулттай байх, тоо бүрээ нягтал, нэр томъёоны орчуулгыг уул уурхайн хүнээр уншуулж шалга. Өгч байгаа зөвлөмж бараг алга, байгаа нь ойлгогдохгүй байна. Зөвлөмж нь Засгийн газрын байгууллагууд юу анхаарах, компаниуд юу анхаарах, ажлын хэсэг, ажлын алба юу анхаарах талаар бичигдсэн байх хэрэгтэй. 20 компанийн 15.4 тэрбумын зөрүүг олж илрүүл.

Пүрэвээ: Зөвлөмжин дээрээ энэ тухайгаа бичээд, цаашид холбогдох байгууллагууд нь олж тогтоох шаардлагатай гээд л бичихэд болно. Жишээ нь Эрдэнэт дээр газрын төлбөр 9 тэрбум зөрснийг анхан шатны баримтыг нь үзээд л олчихно шүү дээ.

Алтансүх: Эрдэнэтийн анхан шатны баримтыг бид шалгасан. Төлбөрийн даалгаврууд нь байгаа, гэтэл орон нутгийн татварын байгууллагаас үүнийг хүлээж авсан гэдэг тоо нь гарахгүй байна.

Н.Дорждарь: Энэ яг юунаас болж Засгийн газар талаасаа гарч ирэхгүй байна?

Алтансүх: Орон нутаг нь буюу Засаг дарга нь өөрийн мэдлийн зардал гээд гаргаж өгөхгүй байна.

Жанцан: Бидэнд энэ тэгсэн байх тэр ингэсэн байх гэж таамаглахаас илүү яг юунаас болоод байна гэдгийг нь тодруулж өгөөч ээ.

Б.Эрдэнэсүрэн: За та бүхэн манай гишүүдийн ярьсан саналуудыг сонслоо. Бид эдгээрийг нэгтгээд боловсруулаад өгье. Харин та нар 14 хоногийн дараа тайлангаа сайжруулаад эргэж танилцуулаарай. Бид харъя.

Александр: Баярлалаа, та бүхэн бидэнд хийсэн ажлаа танилцуулах боломж олгосонд. Мэдээлэл дутуу байснаас зөрүү гарч байгаа гэдэгтэй санал нийлж байна. Бид үүнийг тогтоохын төлөө ажиллая. Мөн орчуулгын талаар ч анхааръя. Та бүхний саналыг тайландаа тусгах болно. Бид илүү их мэдээлэл олж авахын төлөө ажиллах болно. (Танилцуулга хийсэн хүмүүс гарч явав)

Б.Эрдэнэсүрэн: Бидний ажил хоцорч байна. 2008 оны тайланг яаравчлах хэрэгтэй байна. Ялангуяа Ажлын алба ажлаа эрчимжүүлэх хэрэгтэй байна, Татварын ерөнхий газар зэрэг Засгийн газрын агентлагууд анхаарах хэрэгтэй. Хандив, тусламж авсан асуудлыг Засгийн газар дээр ярих нь зөв байна. Сайд нь журам гаргаад байхад Татварын ерөнхий газар зөрж яриад байна, цаашид Татварын ерөнхий газрын тоогоор л явна шүү. Агентлагийн удирдлагууд ажлаа Ерөнхий сайдын өмнө өөрсдөө хариуцаж ярина шүү. Дараагийн Үндэсний зөвлөлийн хуралдаанд Татварын ерөнхий газрын даргыг оруулна шүү. Ажлын албаны сургалт үр дүн муутай байна. Сургалт явуулсан гэдэг хувь хүний орлогын албан татварыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт оруулаад тайлагнаад байгааг яаж ойлгох болж байна. Компаниудтай ажиллах арга барилаа өөрчилъе. Мэдээллийн урсгалыг яаж өөрчлөх вэ, орон нутгаас мэдээлэл яаж авах вэ гэдгийг ажлын алба судал. Орон нутагт орж байгаа бүгдийг дээш нь мэдээлдэг болгоё.

Н.Дорждарь: Маягтыг сайжруулах тал дээр ажилламаар байна. Алтандорнодын асуудал гэж тусдаа босч байх шиг байна. Мөн энэ тайланд Монгол газар ороогүй болохоор баталгаажуулалт дээр сөргөөр нөлөөлж магадгүй. Ингээд томоохон татвар төлөгчид нь орохгүй байгаад байвал тайлангийн ач холбогдол буурна гэсэн үг. Би бол тайлангийн нэгдсэн дүнгээс нь гаргаад тайландаа хавсралт маягаар явуулах хүсэлтэй байна.

Б.Эрдэнэсүрэн: За тэгвэл үүнийг тусад нь гаргая.

Н.Дорждарь: Ер нь Ашигт малтмалын газарт тайланг цуглуулж байгаа нь гээд 20 хоног болгох шаардлага байна уу? Шууд л ажлын албандаа очдог бол ямар вэ?

Ш.Цолмон: Маягтыг сайжруулах тал дээр санал нэг байна. Дэлхийн банкнаас ч гэсэн мэргэжлийн хяналтын байцаагчдын тавьсан торгуул гэсэн төрлийг нэмж оруулаач гэсэн санал хэлсэн. Зарим үзүүлэлтийг нэмээд, заримыг нь хасаад ажлын хэсгээс тусгайлсан баг гаргах нь зөв байх.

Пүрэвээ: Татварын зүгээс тоогоо гаргаж өгөхөд бэлэн. Бид аудитлагдсан тайлангийн дүнг авч байгаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэн Ажлын албанаас боловсруулсан дүгнэлтийг найруулж шийдвэр гаргаж ОУИТБС-ын 2007 оны тайлан гаргаж байгаа Эрнст Янг аудитын компанийн консерциумд гаргаж өгөхөөр тогтов (Дүгнэлтийг хавсаргав).

2. Аудитын компаний өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажилласны дараа эцсийн шатны тайланг Ажлын хэсгийн хуралдаанаар дахин хэлэлцэхээр тогтов.

ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайланд бэлтгэх ажлын явц, тайлан гаргах сонгон шалгаруулалтын тухай Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны буюу 3 дугаар нэгдсэн тайланд бэлтгэх ажлын явц, тайлан гаргах сонгон шалгаруулалтын тухай Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон мэдээлэл хийв.

Э.Сумъяа-Санаачлагын 2008 оны тайланг Засгийн газар яаралтай гаргахад анхаарах хэрэгтэй байна. Аудит хийх компанийг сонгон шалгаруулах баримт бичиг Ажлын албанд бэлэн байгаа. Үүнийгээ эргэж нэг хараад Дэлхийн банкинд явуулж сонгон шалгаруулалт явуулах эрх авах хэрэгтэй байна.

Пүрэвээ-Засгийн газрын 2008 оны тайланг Татварын ерөнхий газар Сангийн яаманд хүргүүлээд байгаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны нэгдсэн тайлан гаргах аудитын компанийн конверциумыг сонгон шалгаруулах баримт бичгийг хянаж Дэлхийн банкинд явуулж зөвшөөрөл аван холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалт зарлах, шалгаруулах арга хэмжээ авахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд үүрэг болгов.

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын тухай гарын авлага боловсруулах тухай

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын гарын авлага боловсруулах тухай Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. ОУИТБС-ын тухай гарын авлагыг төрийн бус байгууллагуудтай хамтран гаргана. Үүний санхүүжилтийг Ажлын албанаас гаргах юм. Энд ажлын хэсгийн зөвшөөрөл хэрэгтэй гэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын гарын авлага төрийн бус байгууллагатай хамтран боловсруулахыг ажлын хэсгийн гишүүд зөвшөөрч,

гарын авлагыг хэн бүхэнд ойлгомжтой, үг хэллэг нь оновчтой байдлаар гаргахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

Б.Эрдэнэсүрэн: За өнөөдөр та бүхэнд хуралдаа идэвхтэй оролцсонд талархлаа. Хурлаа ингээд өндөрлөө.

Ажлын хэсгийн хурал 19 цаг 00 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Б.Эрдэнэсүрэн

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ОУИТБС-ын Ажлын албаны
ажилтан



Т.Хүрэлчимэг